

ГАРИГИЙН НЭРЭЭС ХҮНИЙ НЭР ҮҮСЭХҮЙ

Ц. Сувд *

Монголчууд аливаа ажил үйлийг хийхдээ “Сарын сайныг саатан хүлээж, өдрийн сайныг өнжин хүлээж” тохирожтой сайн өдөр гаригийг сонгон эхэлдэг заншилтай. Шинэ төрсөн хүүхэддээ нэр өгөхдөө ч энэ л ёсоо чанд баримтална.

Монголчуудын дунд эртнээс уламжилсан, нийтлэг нэгэн ёс бол хүүхдийнхээ төрсөн өдөр гаригийн нь нэрийг оролцуулан нэр өгөх ёс билээ. Гарсан өдрийн гариг, төрсөн өдрийн төөрөг гэдэг чухал ойлголт бий. Ийнхүү монголчууд хэдэн зуун жилийн өмнөөс эхлэн гаригийн нэрийг хүүхэддээ өгч байсныг Оросын монголч эрдэмтэн А.М.Позднеев судлан үзэж “Хэрэв төрсөн хүүхдийн эцэг эх хүүхдийн угаал үйлдэхийн хамт ламаар нэр өгүүлэхийг хүсэх юм бол энэ зан үйлд бас л зурхайчийн оролцоо зайлшгүй хэрэгтэй байдаг. Зурхайч нь хүүхдийн төрсөн жил, сар, өдрийг “Биндэрьяа гарав” гэдэг номын 12 дугаар бүлэгт өгүүлсэн зүйлтэй нийлүүлэн бодож тэдгээр заасан зүйлийн үндсэн дээр сая төрсөн хүүхэд нэр өгдөг. Төрсөн хүүхдийн нэрийг өгөхөд монголд хамгийн их хэрэглэдэг арга бол таван гариг гэгчийг шинжлэх явдал бөгөөд буддын одон орныг судлах ухаанд сарын бүх өдөр тэдгээр гаригт хуваагддаг юм. Гариг болгон өөрийн тусгай нэртэй. Энэ нэрийг төрсөн хүүхэд уг төрсөн гаригтай нь тохируулан нэр өгдөг” гэж бичсэн байна. /А.М.Позднеев. 1887 он, 416-417/

Бидний хийсэн судалгааны ажлын үр дүнгээс үзвэл, монголчуудын хамгийн их давтамжтай нэрсээс эхлэн цөөн давтамж бүхий нэрийн дотор хүртэл их долоон гаригийн нэр маш өргөн хэрэглэгдэж байна. Тийм болохоор гаригийн нэр оролцон бүтсэн монгол хүний бүх нэрийн тухай өгүүлэх гэвэл ихээхэн цаг, цаас үрсэн нүсэр ажил болох тул бид энэхүү жижиг өгүүлэлдээ 1000 –аас дээш давтамжтай, түгээмэл хэрэглээ бүхий нэрсийг сонгон авч үзлээ.

Өнөөдөр монголчууд өдөр тутам хэрэглэж байгаа аргын тоололдоо Даваа, Мягмар, Лхагва, Пүрэв, Баасан, Бямба, Ням гэсэн долоон гаригийн төвд нэрийг хэрэглэхийн зэрэгцээ билгийн тоололдоо Сумьяа, Ангараг, Буд, Бархасбадь, Сугар, Санчир, Адьяа гэсэн долоон гаригийн санскрит нэрийг нэгэн адил хэрэглэж байна. Өөрөөр хэлбэл монголчуудын дунд их долоон гаригийн төвд нэр ч, санскрит нэр ч өөрийн хэлний үг мэт ойр дотно хэрэглэгддэг. Тийм учраас долоон гаригийн төвд нэр ч, санскрит нэр ч адилхан монгол хүний нэр болж чаддаг онцлогтой юм.

Өнөөгийн монголчуудын бараг дөрөвний нэгийг нэрлэж байгаа **5000** буюу түүнээс дээш давтамж бүхий түгээмэл хэрэглээтэй **73** нэр /Ц.Сувд. 2010, 27-р тал/-ийн дотор

* Hankuk University of Foreign Studies. Seoul, Korea

*Лхагвасүрэн (9906), Пүрэвсүрэн (8062), Бямбасүрэн (7708), Мягмарсүрэн (6875), Даваасүрэн (6869), Нямсүрэн (6585), Пүрэвдорж (5178)*¹ гэсэн 7 нэр /51183 хүн/ нь гаригийн нэрээс үүсэлтэй байгаа нь санамсаргүй тохиолдол биш ээ. Энэ 7 нэрийн дотроос Лхагвасүрэн гэдэг нэр нь хорьдугаар зууны турш /бусад төвд нэрийн хэрэглэгдэх тоо нь буурсан үзүүлэлттэй байсан ч/ тасралтгүй өссөөр өнөө хүрч ирсэн байна. Бас нэгэн сонин үзэгдэл бол эдгээр 7 нэрийн зургаагийнх нь дараа “Сүрэн” /sgun – сахигч, сахиус гэсэн утгатай төвд үг/24:137/ орсон байгааг үндэслэн, монголчууд хүүхэддээ төрсөн гаригийн нь нэрийг оролцуулан, тухайн төрсөн гариг нь эзнээ насан туршид нь сахин хамгаалагч сахиус болж явахыг бэлгэшээсэн утгатай нэр өгдөг заншил ихэд түгээмэл байдаг гэсэн дүгнэлт хийж болно.

Давтамжийнхаа дарааллаар тэргүүлж байгаа дээрх 73 нэрийн дотор аравхан тохиолдож байгаа төвд гаралтай нэрийн 7 нь гаригийн нэр оролцсон нэр байгаа бол үлдэх 3 нэр нь *Долгор (5093), Долгорсүрэн (5980), Дуламсүрэн (5949)* гэсэн нэр байна. Энэ гурван нэрийн 2 нь мөн л Сүрэн гэсэн нэр оролцсон нийлмэл нэр байгаа ба уг нийлмэл нэрийн эхнийх нь Долгор, Дулам гэсэн нэр байна. Долгор гэдэг нь төвдөөр “sgrol dkar” “гэтэлгэгч цагаан” гэсэн утгатай Цагаан Дар эхийн нэр /Ж.Сэржээ 2007. 62-р тал/ бөгөөд ихэвчлэн эмэгтэй хүнд өгдөг юм. Дулам гэдэг нь төвдөөр “sgrol ma” “гэтэлгэгч эх ” гэсэн утгатай Дар эхийн нэр /Ж.Сэржээ 2007. 66-р тал/ бөгөөд ихэвчлэн эмэгтэй хүнд өгдөг.

Монголчуудын дунд хамгийн өргөн хэрэглэгдэж байгаа дээрх 10 төвд нэрийн 9 нь хоёр нэрээс бүтсэн нийлмэл нэр байгаагаас 8 нь хоёрдугаар хэсэгтээ “сүрэн”-тэй байгаагаас гадна монгол хэлний үгээр бүтсэн мөнх, отгон, бат, цэцэг, чимэг, оюун, баяр гэх мэтийн олон нэр , санскрит хэлний адьяа, арья, сумьяа гэх мэтийн олон нэр бас “сүрэн”-тэй нийлж олон зуун нийлмэл нэр үүсгэдгийг бодолцвол “сүрэн” гэдэг нэр монголчуудын дунд хамгийн өргөн хэрэглэгддэг түгээмэл нэрийн нэгэнд яах аргагүй орж байна. Нэгэнт ийм өргөн хэрэглээтэй нэр болохоор эрэгтэй, эмэгтэй аль ч хүний нэрэнд чөлөөтэй орох ба байрлалын хувьд зөвхөн нийлмэл нэрийн хоёрдугаар хэсэгт ороод зогсохгүй Сүрэнжав, Сүрэнхүү, Сүрэнхорлоо гэх мэтээр нийлмэл нэрийн нэгдүгээр хэсэгт ч идэвхтэй хэрэглэгддэг байна.

Хорьдугаар зууны Монгол улсад **3000-4000 хүртэл давтамжтай 47 нэр** 179104 хүнийг нэрлэж байв. /Ц.Сувд. 2010, 38-р тал/ Энэхүү 47 нэрийн дотор *Бямбадорж 3841, Балжинням (3792), Баасанжав (3657), Нямдорж (3532), Бямбажав (3226)*, гэсэн таван нэр Н+Н буюу нэрийн 2 үндсээс бүтсэн төвд нэр, *Пүрэв (3303), Лхагва (3144), Даваа (3105)* гэсэн гурван нэр Н буюу нэрийн 1 үндсээс бүтсэн төвд нэр байгаа юм. Өөрөөр хэлбэл 47 нэрийн 13 нь төвд гаралтай, үлдсэн 39 нь монгол нэр байсан ба төвд нэрийн ихэнх нь буюу 8 нь гаригийн нэрээс үүссэн байв. Энэхүү найман нэрийн 3 нь буюу Даваа, Лхагва, Пүрэв гэсэн нэрс дангаараа, харин үлдсэн 5 нь Баасанжав, Нямдорж, Бямбажав, Бямбадорж, Балжинням гэсэн нийлмэл нэр үүсгэсэн байна. Эдгээр нийлмэл нэрийн хоёрдугаар хэсэгт орсон “жав” [sgyabs] нь “аврал” /Ж.Сэржээ. 2007. 71-р тал/ , “дорж” [rdo rje] нь “очир, алмааз” гэсэн утгатай /Ж.Сэржээ. 2007. 64-р тал/ ихэвчлэн нийлмэл нэрийн хоёрдугаар хэсэгт ордог төвд гаралтай нэр бөгөөд энэ 3 нийлмэл нэр ихэвчлэн эрэгтэй хүний нэр болдог. Харин Даваа, Лхагва, Пүрэв гурав нь эрэгтэй ч хүний нэр, эмэгтэй ч хүний нэр болдог.

¹⁾ давтамжийн тоо

Монгол хүний нэрийн санд хэрэглэгдэж байгаа их долоон гаригийн Даваа, Мягмар, Лхагва, Пүрэв, Баасан, Бямба, Ням гэсэн төвд нэр, Адьяа, Сумьяа, Буд, Санчир, Бархасбадь, Сугар, Ангараг хэмээх санскрит нэр Давааням, Мягмарлхагва, Пүрэвдаваа, Баасанбямба, Бямбадаваа, Нямдаваа, Нямлхагва гэх мэтээр хоорондоо нийлэн олон мянган нийлмэл нэр үүсгэдэг. Гаригийн төвд нэрээс үүсэлтэй ихэнх хүний нэрийн хэрэглэгдэх давтамж нь 3000 – 5000 хооронд байна. Тухайлбал: *Даваа (3105), Мягмар (2958), Лхагва (3144), Пүрэв (3303), Баасан (1332), Бямба (4548), Ням (2319)* байгаа ба харин гаригийн санскрит нэрс нь 3000-аас доош давтамжтай хэрэглэгддэг байна. Их долоон гаригийн төвд нэрүүд дангаараа болон хоорондоо нийлэн нийлмэл нэр хэрхэн үүсгэдэг зүй тогтол болон нэрийн датамжийн өөрчлөлтийг 1910 оноос эхлэн 1990 оныг дуустал арав арван жилийн мөчлөгөөр үзүүлбэл:

Нэр	1910-19 он	1920-29 он	1930-39 он	1940-49 он	1950-59 он	1960-69 он	1970-79 он	1980-89 он	1990-99 он	дүн
Даваа	120	158	356	493	606	419	385	280	288	3105
Даваамягмар					4	11	14	14	19	62
Даваалхагва			1	2	2	5	3	5	10	28
Даваапүрэв				1	2	6	10	15		34
Даваабаасан					1	1			2	4
Даваабямба					2		1	2	5	10
Давааням	7	16	50	110	221	342	490	585	626	2447
Мягмар	20	79	241	453	580	463	462	369	291	2958
Мягмарлхагва					1	1	1	3	1	7
Мягмарпүрэв						6	5	5	4	20
Мягмарбаасан							1			1
Мягмарбямба						2	1	1	1	5
Мягмарням						1	2	3	9	15
Мягмардаваа				1	1	1	8	15	17	43
Лхагва	43	145	373	538	648	467	363	290	277	3144
Лхагвадаваа			1		1	2	6	7	6	23
Лхагвамягмар						2	1	1	1	5
Лхагвапүрэв			1	2	2	2	6	8	10	31
Лхагвабаасан								1	1	2
Лхагвабямба						1		1		2
Лхагваням			1		3	13	24	29	57	127
Пүрэв	70	232	484	670	683	384	344	219	217	3303
Пүрэвдаваа	1	2	11	22	38	51	94	105	121	445
Пүрэвмягмар					1			1	1	3
Пүрэвлхагва					1	6	2	1	9	19
Пүрэвбаасан		1				6	9	7	16	39
Пүрэвбямба							1	2		3
Пүрэвням			5	12	24	49	73	107	172	442
Баасан	44	70	135	217	234	196	162	154	120	1332

Баасандаваа				1	2	3	6	9	9	30
Баасанмягмар						2		3	2	7
Баасанлхагва						1	2	1		4
Баасанпүрэв						4	15	17	22	58
Баасанбямба				2	2	7	13	11	22	57
Баасанням			2		5	16	20	40	40	123
Бямба	71	235	492	815	1031	659	550	405	290	4548
Бямбадаваа		1		1	7	9	13	14	29	74
Бямбамягмар					1			2	3	6
Бямбалхагва					1	1	2	4	3	11
Бямбапүрэв					1		3	4	4	12
Бямбабаасан					1	1	4			6
Бямбаням				2	8	20	31	46	70	177
Ням	58	136	274	285	436	336	329	241	224	2319
Нямдаваа	8	6	29	82	210	419	471	669	722	2616
Няммягмар							1		1	2
Нямлхагва	1				1	58	92	118	132	402
Нямпүрэв				2		12	23	37	31	105
Нямбаасан							1	1	3	5
Нямбямба							1	1	2	4

Энэ хүснэгтээс : Нэгдүгээрт, монголчууд гаригийн төвд нэрийг 1910 оноос 2000 он хүртэл хүүхэддээ тасралтгүй, байнга өгсөөр ирснийг харж болно. Тухайлбал, Даваа гэдэг нэртэй 1910-19 онд төрсөн 120, 1990-99 онд төрсөн 288 хүн, Мягмар гэдэг нэртэй 1910-19 онд төрсөн 20, 1990-99 онд төрсөн 291 хүн, Лхагва гэдэг нэртэй 1910-19 онд төрсөн 43, 1990-99 онд төрсөн 277 хүн, Пүрэв гэдэг нэртэй 1910-19 онд төрсөн 70, 1990-99 онд төрсөн 217 хүн, Баасан гэдэг нэртэй 1910-19 онд төрсөн 44, 1990-99 онд төрсөн 120 хүн, Бямба гэдэг нэртэй 1910-19 онд төрсөн 71, 1990-99 онд төрсөн 290 хүн, Ням гэдэг нэртэй 1910-19 онд төрсөн 58, 1990-99 онд төрсөн 224 хүн байгаа ба 1950-59 онд хамгийн олон хүн эдгээр гаригийн нэрийг авч байжээ. Хоёрдугаарт, Даваамягмар (62), Мягмардаваа (43), Лхагвапүрэв (31), Пүрэвбаасан (39), Баасанпүрэв (58), Баасанбямба (57), Бямбаням (177), Нямдаваа (2616) гэх мэтээр дараалсан хоёр гаригийн нэрээс бүтсэн нийлмэл нэрийн давтамж бусдаасаа илт олон байна. Үүний учир нь нилээд энгийн бололтой. Тухайлбал эх хүүхдээ төрүүлэхээр ням гаригийн орой эмнэлэгт очоод хэдэн цагийн дараа даваа гаригийн эхээр төрүүлсэн тохиолдол олон бий. Бас Ням гаригийн шөнө эмнэлэгт очоод даваа гаригийн үүрээр /эсвэл өглөө/ хүүхдээ төрүүлсэн байж болно. Ийм тохиолдолд Нямдаваа, эсвэл Давааням гэсэн нэр өгөх нөхцөл бүрдэнэ. Гуравдугаарт, Гаригийн нэрийн дараа “даваа”, “ням” гэсэн хоёр нэр орсон нийлмэл нэртэй хүмүүс илт олон байна. Жишээ нь: Давааням нэртэн 2447, Мягмардаваа нэртэн 43, Мягмарням нэртэн 15, Лхагвадаваа нэртэн 23, Лхагваням нэртэн 127, Пүрэвдаваа нэртэн 445, Пүрэвням нэртэн 442, Баасандаваа нэртэн 30, Баасанням нэртэн 123, Бямбадаваа нэртэн 74, Бямбаням нэртэн 177, Нямдаваа нэртэн 2616 байна. Үүний учир нь, манай монголчууд бусад гаригуудыг бодоход нар сар хоёрыг илүү сайн мэдэх бөгөөд байнга тэднийг харж, эргэх хөдөлгөөнтэй нь ажил амьдралаа зохицуулж байдагт оршино. Дөрөвдүгээрт, Хоорондоо нийлж нийлмэл хүний нэр үүсгэдэггүй гаригийн төвд нэр байхгүй бөгөөд харин зарим нь олон зарим нь цөөн нэр үүсгэдэг ялгаа л бий.

Бидний дунд **2001-3000** давтамжтай нэр бүгд **109** хэрэглэгдэж байгаа ба тэдгээр нь 249942 хүнийг нэрлэж байна. /Ц.Сувд. 2010, 46-р тал/ Эдгээр нэрийн гарлыг авч үзвэл

төвд нэр 26, санскрит нэр 2 байна. 3000 –аас дээш давтамж бүхий түгээмэл нэрийн дотор санскрит гаралтай нэр огт тохиолдоогүй бол, харин энэ хэсэгт *Сумьяа (2771)*, *Адьяа (2506)*, *Банзрагч (2789)* гэдэг гурван нэр байна. Өөрөөр хэлбэл монгол хүний нэрийн санд хамгийн их давтамжтай өргөн хэрэглэгдэж байгаа санскрит нэр бол энэ гурав юм. Эхний хоёр нэр бол хоёулаа гаригийн бөгөөд монгол хүний нэрийн санд эртнээс өнөө хүртэл тасралтгүй хэрэглэгдэж иржээ. Бидний судалгаагаар Сумьяа нэртэн 1910-19 онд төрсөн 61, 1920-29 онд төрсөн 98, 1930-39 онд төрсөн 330, 1950-59 онд төрсөн 475, 1990-99 онд төрсөн 428 хүн байгаа бол, Адьяа нэртэн 1910-19 онд төрсөн 64, 1920-29 онд төрсөн 89, 1930-39 онд төрсөн 243, 1950-59 онд хамгийн их буюу 484, 1990-99 онд 289 төрсөн байв. Үүнээс үзвэл Сумьяа [soma] “сар гэсэн утгатай үг” /Ж.Сэржээ 2007. 136-р тал/, Адьяа [aditya] “нар” гэсэн утгатай үг / Ж.Сэржээ 2007. 15-р тал/ хоёрын давтамж нь ХХ зууны турш өсөлт бууралт багатай жигд байжээ.

Харин төвд хэлнээс гаралтай 26 нэрийн дотор *Лхагвадорж (2997)*, *Лхагважав (2373)*, *Баасансүрэн (2785)*, *Баасандорж (2251)*, *Баасанхүү (2201)*, *Нямдаваа (2616)*, *Даваажав (2453)*, *Давааням (2447)*, *Даваахүү (2039)*, *Дашням (2304)*, *Пүрэвжав (2507)*, *Мягмаржав (2463)* гэх мэт гаригийн нэрээс үүсэлтэй 12 нэр байна. Эдгээр нийлмэл нэрийн давтамж 1990-ээд оноос дахин өсч байгаа нь судалгаагаар харагдаж байв. 1990-ээд оноос давтамж нь өсч байгаа нэрсийн ихэнхийг төвд, санскрит нэр эзэлж байгааг, бас монгол нэрийн нь нилээд хэсгийг “буян, заяа” гэсэн утга агуулгатай нэр эзэлж байгааг Монгол улсад 1990-ээд оноос буддын шашин сэргэж эхэлсэн үйл явцтай холбон үзэх боломжтой юм. Ялангуяа Дашням /“Өлзий наран”/, Балжинням /“Цогийн наран”/ гэсэн нэрсийн давтамж 1990-ээд онд 1980-аад оныхоосоо бараг дөрөв дахин өссөн нь Дашням, Балжиннямтай өдрийг монголчууд бараг нийтээрээ мэддэг болж, тэр өлзийтэй сайн өдөр төрсөн хүүхдэд тухайн өдрийн нь нэрийг өгч байгаатай холбоотой юм.

Монгол хүний нэрийн санд багагүй байр суурь эзэлдэг гаригийн санскрит нэрээс үүсэлтэй нэрийн давтамжийн өөрчлөлтийг хүснэгтээр харуулбал:

№	Нэр	1910-19он	1920-29он	1930-39он	1940-49он	1950-59он	1960-69он	1970-79он	1980-89он	1990-99он	бүгд
1	Адьяа	64	89	243	369	484	315	329	324	289	2506
2	Сумьяа	61	98	330	340	475	331	350	358	428	2771
3	Буд	17	27	74	89	147	98	85	100	96	733
4	Санчир				6	2	5	56	146	381	598
5	Бархасбадь					3		12	18	36	69
6	Сугар	16	42	90	149	198	149	228	259	281	1412
7	Ангараг			1	3	8	14	39	118	148	331

Дээрх хүснэгтээс үзвэл: Нэгдүгээрт, Наран, Саран гэсэн утгатай “Адьяа”, “Сумьяа” хэмээх хоёр нэр 1910 оноос эхлэн 2000 оныг хүртэлх аль ч цаг үед бусдаасаа илт олон давтамжтай хэрэглэгдэж байна. Үүний учрыг өмнө дурдсан Ням, Даваа хэмээх хоёр төвд нэртэй нэгэн адил тайлбарлаж болно. Мөн эдгээр нэрийг эрэгтэй, эмэгтэй ямар ч хүнд өгч болдог нь бас нөлөөлнө. Хоёрдугаарт, Эдгээр гаригийн санскрит нэр нь хоорондоо нийлж нийлмэл нэр үүсгэдэггүйгээрээ төвд гаригийн нэрээс ялгаатай. Гуравдугаарт, Гаригийн санскрит нэр, гаригийн төвд нэр хоёр хоорондоо нийлж монгол хүний нийлмэл нэр бараг үүсгэдэггүй. Дөрөвдүгээрт, Гаригийн санскрит нэр нь өөр хоорондоо нийлж нийлмэл нэр үүсгэдэггүй, бас гаригийн төвд нэртэй нийлж нийлмэл

нэр үүсгэдэггүй онцлогтой учраас монгол хүний нэрийн санд эзлэх нийт тоо нь бага байдаг.

Бид төвд, санскрит гаралтай гаригийн нэрс дангаараа болон өөр хоорондоо нийлж монгол хүний нийлмэл нэр үүсгэж байгаа зүй тогтлын тухай товч өгүүллээ. Үүний зэрэгцээ дээр өгүүлсэн төвд, санскрит гаригийн нэр маань монгол хэлний болон төвд хэлний бусад үгтэй нийлж хэдэн мянган нийлмэл нэр үүсгэдэгийг мартаж болохгүй. Тухайлбал, **1000-2000** давтамжтай **192** нэрийн дотор төвд, санскрит гаралтай нэрийн тоо нилээд нэмэгдэж, 37,2%-ийг нь эзлэх болсон байна /Ц.Сувд. 2010, 50-р тал/ Төвд, санскрит гаралтай тэдгээр нэрийн дотор Даваажаргал (1967), Нямжав (1894), Баасанжаргал (1713), Адьяасүрэн (1694), Нямхүү (1662), Нямбаяр (1492), Мягмардорж (1420), Сугар (1412), Баасан (1332), Даваацэрэн (1175), Даваасамбуу (1038), Даваадулам (1010) гэх мэт гаригийн нэр оролцсон хүний нэр цөөнгүй тохиолдож байна. /Ц.Сувд. 2010 он 198-203-р тал/ Нэр зүйч, доктор Ж.Сэржээ 20 гаруй жилийн өмнө өөрийн нэгэн бүтээлдээ “Пүрэв гэдэг нэрээс Пүрэвбаатар, Пүрэвдагва, Пүрэвжав, Пүрэвсүрэн гэх мэтийн 195 нэр, Даваа гэдэг нэрээс 180, Ням гэдэг нэр 98 нэр үүсгэж байна. Өөрөөр хэлбэл дээрх 7 гаригийн нэр эхэнд нь орсон монгол хүний нийлмэл нэр өнөөгийн байдлаар 912 байгаа юм. Үүний цаана Батням, Ганпүрэв, Цэрэндаваа гэх мэтээр нийлмэл нэрийн хоёрдугаар хэсэгт орсон олон зуун нэр байгааг бодолцох ёстой” гэж бичсэн байдаг нь компьютерийн техник өргөн хэрэглэх болсон өнөөдөр ч ач холбогдлоо алдаагүй байна. /Ж.Сэржээ 1992 он 74-р тал/

НОМЗҮЙ

1. Позднеев А.М. (1887). Очерки быта буддийских монастырей и буддийского духовенства в Монголии. Санкт-Петербург.
2. Сувд Ц. (2010). Хорьдугаар зууны монгол хүний нэр /нэрийн давтамж, гарал, утга, бүтэц/ УБ.
3. Сэржээ Ж. (1992). Монгол хүний нэр. УБ.
4. Сэржээ Ж. (2007). Монгол хүний нэрийн толь, УБ.

SUMMARY

Mongolians have a long tradition and custom of naming their children after days of the week. Tibetan names of solar calendar for the days of the week like Даваа, Мягмар, Лхагва, Пүрэв, Баасан, Бямба, Ням and Sanskrit names of lunar calendar like Сумьяа, Ангараг, Буд, Бархасбадь, Сугар, Санчир, Адьяа are common names. These names cannot be only used as personal names itself but also combine together such as Давааням, Мягмарлхагва, Пүрэвдаваа, Баасанбямба, Бямбадаваа, Нямдаваа, Нямлхагва that compose numerous compound names.

In this article, the author studied the frequency of the personal names which derive from Tibetan and Sanskrit names of the days of the week such as *Лхагвасүрэн* (9906), *Пүрэвсүрэн* (8062), *Бямбасүрэн* (7708), *Мягмарсүрэн* (6875) and *Даваасүрэн* (6869) have been found over 3000 and *Сумьяа* (2771), *Адьяа* (2506) have been found 3000 times less.